

**БИЕИЙН ТАМИРЫН ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨН ОЮУТАН ЗАЛУУСЫН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГТ
НӨЛӨӨЛӨХ НЬ
(МУИС-ИЙН ОЮУТНУУДЫН ЖИШЭЭН ДЭЭР)**

*Р. Гантулга доктор, дэд проф.
Ж. Бандхүү магистр, ахлах багш
Л. Эрдэнэпүрэв магистр, ахлах багш
Ц. Сумъяабэйс Магистр, Ахлах багш
МУИС, БИЕИЙН ТАМИРЫН ТЭНХИМ*

Abstract: *Lack of physical activity and obesity have become one of society's health challenges. The purpose of this study is to determine level of fitness, physical development and body mass index (BMI) of university students, and define the importance of physical activity. Personal information of the study participants' such as sex, age (birth year), height (in meters), weight (in kg) and BMI (kg/m²) was obtained using known calculation methods. Fitness level was determined using frequency, volume and time duration of physical activity performed per week on average using questionnaire method. 93 percent of all male students and 74 percent of female students who participated in the study are engaged in some kind of physical activity. 89 percent of all male students and 67 percent of female students train twice or more times per week. This led us to believe the students understand the importance of being active.*

Key word: physical activity, female students, students train.

Оршил

Шинжлэх ухаан, техникийн эрчимтэй хөгжлийн өнөө үед хүний биеийн хүчний хөдөлмөр багасаж, мэдээлэл технологийн хүчийг ихээр ашиглах, дижитал буюу цахим орчинд ихэнх цагаа өнгөрүүлэн биеийн тамирын дасгал хөдөлгөөнд бага цаг зарцуулж байгаатай холбоотойгоор бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн түвшин шаардлагатай түвшинд хүрэхгүй, хөдөлгөөний дутагдалд өртөх эрсдэлт хүчин зүйл болж байна.

ДЭМБ 2020 онд “Биеийн тамирын дасгал, хөдөлгөөн багатай зан үйлийн талаарх шинэ удирдамж”-ийг боловсруулсан. Энэ удирдамж нь ДЭМБ-ын 2010 онд гаргасан өмнөх зөвлөмжүүдийг шинэчилж, биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх нь эрүүл мэндийг сайжруулах, хөдөлгөөн багатай зан үйлийг бууруулах, аэробик болон булчинг бэхжүүлэх дасгалуудыг тогтмол хийж байхын ач холбогдлыг онцолж 2018–2030 (World Health Organization. Global action plan on physical activity 2018-2030: more active people for a healthier world., 2018) он хүртэлх биеийн хөдөлгөөний үйл ажиллагааны шинэ төлөвлөгөөг баталж, 2030 он гэхэд насанд хүрэгчид болон өсвөр үеийнхний хөдөлгөөний дутагдлыг дэлхийн хэмжээнд 15 хувиар бууруулах сайн дурын шинэ зорилт бүхий зөвлөмж гаргаж нийтийн хүртээл болгосон.

Дэлхийн хамгийн сүүлийн үеийн тооцоогоор насанд хүрэгчдийн 27.5% (Guthold R, Stevens GA, Riley LM, et al., 2018), өсвөр насныхны 81% (Guthold R, Stevens GA, Riley LM, et al., Lancet Child Adolesc Health)нь 2010 оны Эрүүл мэндийн төлөөх биеийн тамирын дэлхийн зөвлөмжид дурдсанчлан аэробик дасгал хийх зөвлөмжийг хангадаггүй болохыг тогтоожээ². Эрүүл мэнд болон бусад гол салбаруудын аль алинд нь биеийн тамирын дасгал сургуулилтыг дэмжих үйлчилгээнд чиглэсэн тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Нас, үндэс угсаа, эрүүл мэндийн байдал зэргээс үл хамааран бараг бүх хүмүүс биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг тогтмол хийснээр ашиг тус хүртдэг болохыг эрдэмтэн судлаачдын

бүтээлд нотолсон байдаг (Centers for Disease Control and Prevention (2011) Physical activity and fitness, 2020). Үнэн хэрэгтээ биеийн тамирын дасгал сургуулилтыг тогтмол хийх нь бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндэд чухал ач холбогдолтой юм. Тогтмол, дунд зэргийн ачаалалтай биеийн тамирын дасгал хийснээр бүх шалтгааны улмаас нас баралт мэдэгдэхүйц буурч, зүрхний ишемийн өвчин, таргалалт, цусны даралт ихсэх, тархины судасны өвчин, 2-р хэлбэрийн чихрийн шижин, сэтгэл гутрал буурч, бодисын солилцооны идэвхжил сайжирдаг (Kim, J., Must, A., Fitzmaurice, G.M., Gillman, M.W., Chomitz, V., Kramer, E., McGowan, R. and Peterson, K.E., 2005). Мөн Калфас нар, 1994 оны бүтээлдээ биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийснээр өөрийгөө үнэлэх үнэлэмж, өөртөө итгэх итгэл сайжирч, сэтгэл гутралын шинж тэмдэг буурч байгааг тогтоосон (Calfas, K.J. and Taylor, W.C. , 1999). Нэмж дурдахад, биеийн тамирын дасгалаар тогтмол хичээллэх нь булчингийн үйл ажиллагаа, зүрх судасны үйл ажиллагаа, бие бялдрын гүйцэтгэлийг сайжруулдаг болохыг харуулж байна. Судлаачид суралцахад туслах оюун ухаан, бие махбодын хоорондох хэд хэдэн холбоосыг анхаарч үзсэн. Олон улсын эрдэмтдийн бүтээлд оюутан залуучуудын эрүүл мэндийг бэхжүүлэх, биеийн хүч тамирыг хөгжүүлэх, бие эрхтний үйл ажиллагааг идэвхжүүлэх, оюуны болон биеийн хүчний ажиллах чадварыг дээшлүүлэх, бие хүнийг төлөвшүүлэхэд биеийн тамир, спорт чухал үүрэгтэй болохыг тогтоожээ.

Эрдэмтэд эрүүл идэвхтэй амьдралын гол шалгуурыг тодорхойлсон байдаг. Оюутнуудын амьдралын хэв маягийн үнэт зүйлс бол биеийн тамирын дасгал сургуулилтад тогтмол хамрагдах (Imas Y.V. Dutchak M. V, Andrieieva O. V. Kashuba V. O.et.al, 2018), таргалалтаас урьдчилан сэргийлэх, эрүүл хооллолтыг баримтлах сонирхолтой (Allison C. Sylvetsky, Monique Hennink, Dawn Comeau et.al, 2013), эрүүл мэндийн зан үйл, байгаль орчны эрсдэлт хүчин зүйлс (Hannah G. Lawman, Dawn K. Wilson, 2012), сэтгэлийн хямралтай холбоотой амьдралын хэв маягийн хүчин зүйлүүд (Alejandra Aguilar-Latorre, Maria J. Serrano-Ripoll, Bárbara Oliván-Blázquez et.al, 2022), биеийн хөдөлгөөний мэдлэгийн түвшин хэмээн тодорхойлжээ.

Оюутан залуучуудын эрүүл мэндийн байдал, бие бялдрын хөгжил зэрэг нь амьдралын хэв маягаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд оюутан өөрийн амьдралынхаа дадал, хэв маягт анхаарлаа хандуулах нь тэдний ухамсар, төлөвшил, дадал, зуршил болон хувь хүний зохион байгуулалттай холбоотой асуудал гэж үзэж байна.

Судалгааны зорилго

Хөдөлгөөний хомсдол, таргалалт нь нийгмийн эрүүл мэндийн яаралтай шийдвэрлэх тулгамдсан асуудлын нэг болж байна. Энэхүү судалгааны зорилго нь их сургуулийн оюутнуудын биеийн тамирын дасгал, бие бялдрын хөгжил, биеийн жингийн индексийн түвшнийг тодорхойлох биеийн тамирын дасгалын ач холбогдлыг тодорхойлоход оршино.

Судалгааны ажлын зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьж шийдвэрлэсэн. Үүнд:

- Биеийн тамирын дасгал, бие бялдрын хөгжлийн түвшин, биеийн жингийн индексийн түвшнийг тодорхойлох
- Судалгааны хаалттай болон нээлттэй асуулга анкетыг боловсруулах, асуулга судалгааг авах
- Судалгааны мэдээллийг цуглуулж, SPSS 23 программаар дүн шинжилгээ хийх

Судалгааны арга зүй: Энэхүү судалгааны ажилд доор дурдсан арга зүйг ашиглав.

Судалгаанд оролцогчдын хувийн мэдээллийг хүйс, нас (жилээр), өндөр (см), жин (кг), БЖИ ((кг/м²) тооцоолох аргуудыг ашигласан. Биеийн жингийн индексийг 1985 оны Ж.С.Гарроу, Ж.Вебстер (Garrow JS, Webster J., 1985), 2012 оны Ансел Кис, Фламинно Фиданза, (Fidanza F,

Karvonen MJ, Kimura N, Taylor HL., 2014) нарын бүтээлд дурдагдсан Кетелетийн индекс (W/H2)-ийн аргаар тооцоолон гаргасан.

Бидний биеийн жингийн индекс (БЖИ)-г тодорхойлох аргачлал:

$$\text{БЖИ-Биеийн жингийн индекс} = \frac{\text{БЖ-Биеийн жин (кг)}}{\text{БӨ-Биеийн өндөр (см)}^2}$$

Дараа нь БЖИ-ийг тураалтай (BMI <18.5), хэвийн жин (BMI 18.5-24.9), илүүдэл жинтэй (BMI 25.0-29.9) болон таргалалт (BMI ≥ 30) (1995;854:1 –452., 1995) гэж эрдэмтдийн хийсэн тооцоолол дээр үндэслэн хуваасан.

Биеийн жингийн үнэлгээ						
	Туранхай	Хэвийн жин	Илүүдэл жинтэй	Таргалалт I зэрэг	Таргалалт II зэрэг	Таргалалт III зэрэг
эмэгтэй	<18.5	18.5-24.9	25.0-29.9	30.0-34.9	35.0-39.9	>40.0

Баталгаат жин, өндөр хэмжигч хэрэглэн, жингээ өглөө босоод бие зассаны дараа эсвэл хоол цай хэрэглэхийн өмнө, хэрэглэснээс хойш 2-3 цагийн дараа хэмжих шаардлагатай байдаг. Бид судалгаанд оролцогч оюутнуудын биеийн жинг хэмжээг энэ шаардлагын дагуу авсан.

1. Асуулга судалгааны аргаар судалгааг авсан ба асуулга нь дараах бүлэгт хуваагдсан. Үүнд: Оюутны товч мэдээлэл, амьдралын хэв маяг, дасгал хөдөлгөөний талаар ойлголт
2. МУИС-ийн 1-5-р түвшний биеийн тамирын хичээл судалж буй оюутны судалгааны материалыг математик статистикийн аргаар боловсруулалт хийсэн. Түүвэрлэлтийг хийхдээ статистикийн түүвэр судалгааны арга зүйд тулгуурласан болно.
3. Судалгааны статистик боловсруулалтын SPSS программ зэрэг болно.

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


Бидний судалгаанд МУИС-ийн бакалаврын 1-с 5 дугаар түвшний 18.1±3.14 насны 394 оюутан оролцсон ба нийт оюутны 54% нь эмэгтэй, 46% нь эрэгтэй байлаа.

17 настай оюутан 8%, 18 настай оюутан 70.64%, 19 настай оюутан 18.05%, 20 настай оюутан 2.28%, 21-ээс дээш настай оюутан 1.02%-ийг эзэлж байв.

Судалгааны үр дүн


Хүн бүр дахин давтагдашгүй учраас биеийн жин нь биеийн өндөрт л тохирсон байх ёстой. Энэ үзүүлэлт нь таныг биеийн өндөр, одоо байгаа жингээс тань хамааруулж хэвийн жинтэй юу, жингийн илүүдэлтэй юу гэдгийг тодорхойлно гэсэн ойлголт юм.

Зураг 1. Судалгаанд оролцогчдын биеийн өндөр, цээжний тойргийн үзүүлэлт



Биеийн ерөнхий хөгжлийн үзүүлэлтээс харахад хөвгүүд охидоос илүү өндөр байгаа бөгөөд дунджаар 16 см өндөр, цээжний тойрог 3.33 см-ээр илүү байна.

Зураг 2. Судалгаанд оролцогчдын биеийн жин, биеийн жингийн индексийн



харьцуулсан үзүүлэлт

Биеийн жингийн индексийн дундаж үзүүлэлтийн харьцуулалтаас харахад хэвийн түвшинд байгаа боловч нийт эрэгтэй оюутнуудын 3% нь (BMI>25) илүүдэл жинтэй, 4.10% нь I зэргийн таргалалттай, эмэгтэй оюутнуудын 3.34% нь (BMI>25) илүүдэл жинтэй, 2.58% нь I зэргийн таргалалттай байсан. Мөн эрэгтэй оюутнуудын 13.94%, эмэгтэй оюутны 12.87% нь туранхай байсан.

Хүний биеийн жингийн индексийг хэвийн хэмжээнд байлгах нь эрүүл, идэвхтэй амьдралын чухал зорилгуудын нэг байдаг. Өөрийн биеийн өндөртөө тохирсон биеийн жинтэй байх, мөн биед байх булчингийн масс, өөхний харьцаанд анхаарч байх нь чухал байна.

Биеийн тамирын дасгал, хөдөлгөөний түвшин, дасгалын тухай ойлголт болон чиг хандлага


Бидний судалгаанд оролцогч оюутнууд эрэгтэй оюутнуудын 93% нь, эмэгтэй оюутнуудын 74% нь биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэг бөгөөд эрэгтэй оюутнуудын 89%, эмэгтэй оюутнуудын 67% долоо хоногт хоёр буюу түүнээс олон удаа дасгал хийдэг гэж мэдээлсэн бол эрэгтэйчүүдийн 3%, эмэгтэйчүүдийн 6% бараг өдөр бүр дасгал хийдэг, харин эрэгтэйчүүдийн 7%, эмэгтэйчүүдийн 32% нь огт дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэггүй гэж хариулжээ.

Бие бялдрын хөгжлийн түвшингөө үнэлэхдээ эрэгтэй оюутнуудын 59% нь дундаж, 35% нь сайн, маш сайн, эмэгтэй оюутнуудын 53% нь дундаж, 28% нь сайн, маш сайн, биеийн галбираа эрэгтэй оюутнуудын 24% нь дундаж, 34% нь сайн, маш сайн, эмэгтэй оюутнуудын 45% нь дундаж, 42% нь сайн, маш сайн, гэж үнэлсэн байна. Бие бялдрын түвшин, биеийн галбиртаа сэтгэл хангалуун байна гэж судалгаанд оролцогч эрэгтэй оюутнуудын 62% нь, эмэгтэй оюутнуудын 76% нь мэдэгдсэн байна.

ДЭМБ-ийн 2020 онд гаргасан удирдамжид долоо хоногт дунджаар 150-300 минутын дунд зэргийн эрчимтэй эсвэл 75-150 минутын хүчтэй эрчимтэй дасгал идэвхтэй амьдралын хэв маягт тохирно гэж заасан байдаг.

Манай судалгаанд оролцогч эрэгтэй оюутнуудын 31%, эмэгтэй оюутнуудын 17% нь дасгалын давтамж, эрч хүч, үргэлжлэх хугацаа нэг хоногт 30 минутын эрчим өндөртэй дасгалыг санал болгож буй хамгийн бага шалгуурыг хангасан байна (p<.001). Долоо хоногт 300 минутын хамгийн сүүлийн үеийн хатуу шалгуурыг эрэгтэй оюутнуудын 17%, эмэгтэй оюутнуудын 3% нь хангасан байна.

Зураг 3. Судалгаанд оролцсон оюутнуудын спортоор хичээллэж байгаа түвшин




Спортоор тогтмол хичээллэдэг эрэгтэй оюутнуудын 52%, эмэгтэй оюутнуудын 46% нь дунд түвшний хичээллэгч байна. Ахисан түвшин буюу 5-аас дээш жил спортоор хичээллэж байгаа оюутнууд харьцангуй бага байгаа харагдаж байна.

Биеийн тамирын дасгалаар долоо хоногт 2-оос дээш удаа тогтмол хичээллэдэг ахисан түвшний хичээллэгч эрэгтэй оюутнуудын 69% нь, эмэгтэй оюутнуудын 73% нь "өөрсдийгөө маш шахаж бэлтгэл хийдэг, амьсгаа өндөртэй, хөлс нь их урсдаг" гэж хариулсан ба ялангуяа эрэгтэй оюутнууд "өөрсдийгөө ядарч туйлддаг" гэсэн нь тэд дасгалыг эрчим өндөртэй хийдэг нь харагдаж байна. Эрэгтэй оюутнуудын 48%, эмэгтэй оюутнуудын 31% нь нэг удаагийн бэлтгэлээ 60 минутаас дээш хугацаанд, эрчим өндөртэй хийдэг гэж мэдээлжээ.

Бидний судалгаанд оролцогчдын 90% нь биеийн тамирын хичээл, спортоор хичээллэх сонирхол, хандлага өндөртэй, эрэгтэй оюутнуудын 79%, эмэгтэй оюутнуудын 83% нь идэвхтэй амьдралын хэв маягийн төлөвшилтэй, 20% нь биеийн тамирын дасгалаар хичээллэх арга барил эзэмшээгүй гэж хариулжээ. Оюутан залуусаас дасгал хөдөлгөөнөөр хичээллэх боломжит нөхцөл хэр байдгийг судалж үзэхэд хангалтгүй гэж хариулсан ба тэдний 73% нь оюутны хотхон болон суралцах орчинд байрлах дугуйн болон явган алхалтын зам, гүйлтийн цэцэрлэгт хүрээлэн, спорт талбай, иог, фитнесийн болон спорт тоглоомын заал, усан бассейныг хангалттай нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн байна.

Зураг 4. Судалгаанд оролцогчдын дасгал хөдөлгөөний ач холбогдлыг тодорхойлсон үзүүлэлт



Судалгаанд оролцогчдоос биеийн тамирын дасгалын ач холбогдлын талаар асуусан эрэмбэлэх асуулгад эмэгтэй оюутнуудын 71% нь хөдөлгөөн дутагдлаас сэргийлэх, 70% нь сэтгэл санаа эрч хүчтэй болох, 65% нь биеийн галбираа сайжруулахад ач холбогдолтой гэж үзжээ. Эрэгтэй оюутнуудын 59% нь хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, 55% нь биеийн жингээ тогтмол барих, галбираа сайжруулах, сэтгэл санааны эрч хүчтэй байдлыг олж авдаг гэж хариулсан байна.

Дүгнэлт

Судалгаанд оролцогч оюутнуудын ихэнх нь биеийн тамирын хичээл бол эрүүл мэндийг сайжруулах, бие бялдрыг хөгжүүлэх чухал хэрэглүүр гэдэгтэй санал нийлдэг гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Судалгаанд оролцогчдын биеийн тамирын дасгалаар хичээллэх давтамж, эрчим, дасгалын ач холбогдолд ойлгож байгаа дүгнэлтээс харахад идэвхтэй амьдралын хэв маягийг өөртөө төлөвшүүлэх зорилго тавьж, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх хүсэл сонирхолтой байгаа нь харагдаж байна.

Биеийн тамирын дасгалаар хичээллэх ач холбогдлыг оюутнууд

1. Судалгаанд оролцогч эрэгтэй оюутны 74.59%, эмэгтэй оюутны 74.85% нь "Биеийн жингийн индексээ хэвийн хэмжээнд барих
2. Эрэгтэй оюутны 89%, эмэгтэй оюутны 67%" нь "Долоо хоногт хоёр буюу түүнээс олон удаа биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллэх" нь тохиромжтой гэсэн хариултуудаас харагдаж байна.

Биеийн тамирын хичээл, дасгал сургуулилтын талаарх оюутны үзэл баримтлалд нөлөөлөх, бие бялдрын хөгжил, чадавх, бэлтгэлжилт, ур чадварыг дээшлүүлэх, гаргасан үр дүн, амжилтыг дэмжин, суралцах чадварт нөлөөлөн сургалтын эерэг орчныг бий болгох нь биеийн тамирын дасгалыг тогтмол, насан туршдаа хичээллэх гол хүчин зүйл болж, тэдэнд хэрэгцээ, сонирхол бий болгож, бие бялдрын эрүүл амьдралын хэв маягийн сэдэл, хандлага төлөвшүүлнэ гэж бид үзэж байна.

Ном зүй

- Alejandra Aguilar-Latorre, Maria J. Serrano-Ripoll, Bárbara Oliván-Blázquez et.al. (2022). Associations Between Severity of Depression, Lifestyle Patterns, and Personal Factors Related to Health Behavior: Secondary Data Analysis From a Randomized Controlled Trial. *Sec. Health Psychology*, 13 - 2022. doi:10.3389/fpsyg.2022.856139
- Allison C. Sylvetsky, Monique Hennink, Dawn Comeau et.al. (2013). Youth Understanding of Healthy Eating and Obesity: A Focus Group Study. *Hindawi Publishing Corporation Journal of Obesity*, 2013, Article ID 670295, . doi:10.1155/2013/670295
- Calfas, K.J. and Taylor, W.C. . (1999). Effects of physical activity on psychological variables in adolescents. (6, 406-423.).
- (2011). *Centers for Disease Control and Prevention (2011) Physical activity and fitness. . Healthy people 2020: Physical activity. .*
- Fidanza F, Karvonen MJ, Kimura N, Taylor HL. (2014). Indices of relative weight and obesity. *43, Issue (3, June 2014,), 655–665. doi:10.1093/ije/dyu058*
- Garrow JS, Webster J. (1985). *Quetelet 's index (W/H2) as a measure of fatness*. Int J Obes.
- Guthold R, Stevens GA, Riley LM, et al. (2018). Worldwide trends in insufficient physical activity from 2001 to 2016: a pooled analysis of 358 population-based surveys with 1•9 million participants. *Lancet Glob Health* 2018, 2018;6:e1077–86. doi:10.1016/S2214-109X(18)
- Guthold R, Stevens GA, Riley LM, et al. (Lancet Child Adolesc Health). Global trends in insufficient physical activity among adolescents: a pooled analysis of 298 population-based surveys with 1•6 million participants. *Lancet Child Adolesc Health* 2020;4:23–35. doi:10.1016/S2352-4642(2020;4:23–35. doi:10.1016/S2352-4642(
- Hannah G. Lawman, Dawn K. Wilson. (2012). A Review of Family and Environmental Correlates of Health Behaviors in High-Risk Youth. *Reviews Behavior and Psychology, Obesity (2012) 20., 1142–1157. doi:10.1038/oby.2011.376*

- Imas Y.V., Dutchak M. V., Andricieva O. V., Kashuba V. O.et.al. (2018). Modern approaches to the problem of values' formation of students' healthy lifestyle in the course of physical training.
- Kim, J., Must, A., Fitzmaurice, G.M., Gillman, M.W., Chomitz, V., Kramer, E., McGowan, R. and Peterson, K.E. (2005). Relationship of physical fitness to prevalence and incidence of overweight among schoolchildren. (2005 13, 1246-1254.). doi:doi:10.1038/oby.2005.148
- (2018). *World Health Organization. Global action plan on physical activity 2018-2030: more active people for a healthier world.* Geneva: : World Health Organization .
- (1995). *World Health Organization. Physical status: the use and interpretation of anthropometry. Report of a WHO Expert Committee.* World Health Organ Tech Rep Ser.

Шинэ номын танилцуулга:

Социологи, нийгмийн ажлын тэнхимийн профессорын их семинар “Социологи” сурах бичиг номын хэлэлцүүлгийн хүрээнд зохион байгуулагдлаа.

МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимээс профессорын их семинарыг санаачлан зохион байгуулж эхэлсэн билээ. Энэ жил их семинарын хүрээнд МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн дэд профессор, доктор С.Түмэндэлгэрийн “Социологи” сурах бичиг номын хэлэлцүүлгийг 2024 оны 03 сарын 07-нд амжилттай зохион байгууллаа. Семинарыг нээж МУИС-ийн Нийгмийн ухааны сургуулийн дэд захирал, доктор Ч.Тамир үг хэлж, эрдэмтдийн их семинарыг жил бүр тогтмол хийхээ мэдэгдлээ.

Сурах бичгийн хэлэлцүүлэгт МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч доктор, дэд профессор Г.Түмэннаст, доктор профессор Ш.Оюунханд, доктор, профессор Т.Бүрэнжаргал, доктор, дэд профессор С.Нарантуяа, доктор, дэд профессор М.Батбаатар, доктор дэд профессор Н.Болдмаа, доктор, ахлах багш Т.Баярцэцэг, доктор, ахлах багш С.Мөнхбаатар, ахлах багш Ц.Болд, ахлах багш Д.Оюунцэцэг, багш А.Тэнүүнжаргал, багш Б.Нандинцэцэг болон урилгаар ахмад социологич, доктор Ч.Эрдэнэчулуун, Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуулийн социологич доктор С.Тулга, МУИС-ийн философийн ухааны доктор, профессор Г.Цэрэн, ШУТИС-ийн доктор, профессорын багийн ахлагч Т.Оюунбилэг, Нийгмийн эрүүл мэндийн судлаач, доктор Б.Сувд, Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгийн захирал, МУИС-ийн докторант Ц.Одгэрэл нар оролцон өөрсдийн асуулт, санал, шүүмжээ хуваалцлаа.

Хэлэлцүүлгийг социологич, МУИС-ийн ахлах багш Д.Мөнхтөр удирдан явуулж, үндсэн шүүмжийг доктор, дэд профессор П.Цэрэнбазар хэлэлцүүлж, редакторын багийг төлөөлж доктор дэд профессор Я.Отгонбаяр танилцуулга хийлээ.

Социологи сурах бичгийн онцлогийг шүүмжлэгч судлаач, эрдэмтэд дүгнэхдээ өрнийн шинжлэх ухааныг дорнын ухаан, тэр дундаа Монгол оюунаар шүүж, тунгаан бичсэн дэг, бүтэц сайтай сурах бичиг болсныг онцлоод, зарим бүлэг сэдвүүдэд гадаад судалгааг эш татсан нь Монголын социологичид тухайн чиглэлийн судалгааг хийх шаардлага, хоосон орон зай байгааг харуулж байна хэмээн өргөн утгаар дүгнэлээ. Редакторын дүгнэлтээр тухайн бүтээл нь сурах бичгийн агуулга, стандартыг бүрэн хангасан бүтээл болсон гэж дүгнээд, цаашид социологичид аль салбарт судалгаа хийх шаардлагатайг харуулсан бүтээл болсон гэдэг шүүмжтэй санал нийлсэн юм.

ШУТИС-ийн доктор Т.Оюунбилэг өөрийн “Социологи” сурах бичгийг сургалтад ашигласан ажиглалтаасаа хуваалцан, сурах бичгийг нэг жил социологийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад ашиглахдаа оюутнуудын хувьд шинжлэх ухааны дэг, ойлголт,

хандлагыг эх хэлээрээ уншин танилцах нь гүнзгий эргэцүүлэл хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах боломжийг олгосон хэмээн дүгнэсэн юм.

Социологи, нийгмийн ажлын тэнхимийн зүгээс зохиогч, социологич С.Түмэндэлгэр докторт цаашдын судалгаа, эрдмийн бүтээлд нь өндөр амжилт хүсэн “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цуврал, номын дээжийг тэнхимийн эрхлэгч доктор Г.Түмэннаст гардуулан өглөө.

Уг семинарын зорилго нь нийгмийн ухааны чиглэлийн эрдэмтдийн бүтээлийг хэлэлцүүлэх, санал солилцох, шинэ санаачилга нэвтрүүлэхэд чиглэгдэж байна. Иймд эрдэмтдийн их семинарыг МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимээс жил бүр хийх төлөвлөгөөтэй байна.